



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 346

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг
томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 4.2 дахь заалт, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн ХЭГ/989 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн ХЭГ/989 тоот санал, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн 05/7358 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ахлах референт Н.Мөнхбатыг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ